



ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

СОГТУУРУУЛАХ УНДААНЫ ХЭРЭГЛЭЭ,
ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ



Улаанбаатар
2019 он

Согтууруулах ундаа нь хүн төрөлхтний дунд олон зуун жилийн турш, өргөн хэрэглэгдэж ирсэн хүнийг донтуулах, сэтгэцэд нөлөөлөх шинж чанартай бодис юм. Үүнийг хэтрүүлэн хэрэглэх нь хувь хүний эрүүл мэндэд шууд хортой төдийгүй гэр бүл, найз нөхөд, хамтран ажиллагчдад дам байдлаар хор хөнөөл учруулж, улмаар нийгэм, эдийн засагт дарамт үүсгэдэг байна.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын мэдээллээр архи хэтрүүлэн хэрэглэсний улмаас дэлхийд 1 жилд 3 сая, өөрөөр хэлбэл, 1 минутад 6 хүн нас барж байна. Эдгээр хүний 4 хүн тутмын 3 нь эрэгтэй байна. Мөн 2016 оны байдлаар дэлхийн 15, түүнээс дээш насны 1 хүн жилд 6.4 литр “спирт”¹ хэрэглэж байгаа тооцоо гарчээ.

Улс, орнууд архины хэрэглээнээс үүдэн хүний эрүүл мэнд, аюулгүй байдал, нийгэм-эдийн засагт гарах сөрөг нөлөөг багасгахад үр дүнтэй, уялдаа холбоотой олон талт арга хэмжээ, бодлогыг авч хэрэгжүүлж байна. Тухайлбал, согтууруулах ундааны маркетинг, сурталчилгаа болон борлуулалтыг хуулиар зохицуулах (ялангуяа залуучуудад чиглэсэн); согтууруулах ундаа худалдан авах боломжийг хязгаарлах, зохицуулах; согтуугаар жолоо барихыг хориглох бодлого хэрэгжүүлэх; үнэ болон татварын механизмаар дамжуулан эрэлтийг бууруулах; олон нийтэд согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэхэд эрүүл мэндэд учруулах хор нөлөөг таниулах, мэдлэг олгох үр дүнтэй бодлогыг дэмжих; архинаас хамааралтай хүмүүст хүртээмжтэй, үр дүнтэй эмчилгээг хүргэх; архи хэтрүүлэн хэрэглэх явдлыг хянах бодлого, хөтөлбөрийг эрүүл мэндийн үйлчилгээнд нэвтрүүлэн хэрэгжүүлэх² зэрэг байна.

Монгол Улсад архидан согтуурахтай тэмцэх хуулийг 2000 онд батлан мөрдөгдөж байгаа бөгөөд бусад холбогдох хууль, журамд архины хэрэглээ, үйлдвэрлэлийг хязгаарлах, зохицуулах талаар тусгасан байна. Мөн “Архидан согтуурахаас сэргийлэх, хяналт тавих үндэсний хөтөлбөр”-ийг батлан, 2003-2012 онд хэрэгжүүлсэн байна.

Согтууруулах ундааны хэрэглээ нь олон төрлийн өвчин эмгэг болон осол гэмтэл, хүчирхийлэл, гэмт хэрэг зэргийг өдөөх эрсдэлт хүчин зүйл болж, нийгэмд сөрөг нөлөөтэй учраас энэ талаарх эдийн засгийн болон нийгмийн холбогдолтой зарим динамик мэдээллийг ашиглан өнөөгийн байдлыг харуулахыг зорилоо.

¹ Спиртийн хэмжээг тухайн согтууруулах ундааны төрлөөс хамааруулан, түүнд ногдох спиртийн агууламжаар тооцдог байна / <https://unstats.un.org/sdgs/metadata/files/Metadata-03-05-02.pdf/>

² <https://www.who.int/en/news-room/fact-sheets/detail/alcohol>

Монгол Улсын согтууруулах ундааны үйлдвэрлэл болон экспорт, импортын өнөөгийн байдал

Согтууруулах ундаа үйлдвэрлэл нь эдийн засгийн үйл ажиллагааны ангиллын дагуу “ундаа үйлдвэрлэл” салбарт хамрагдах бөгөөд тус салбарын үйлдвэрлэл 2017 онд 671.0 тэрбум төгрөгт хүрч, 2008 оноос 4 дахин, борлуулалт 740.9 тэрбум төгрөгт хүрч, 2008 оноос 5 дахин тус тус нэмэгдсэн байна.

Харин аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэл болон борлуулалтад ундаа үйлдвэрлэлийн эзлэх хувь буюу бүтцийг авч үзвэл өөрчлөлт бага, 2008-2017 онд дунджаар нийт үйлдвэрлэлийн 4.6 хувь, борлуулалтын 5.8 хувийг эзэлж байна.

Хүснэгт 1. Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл, борлуулалт, оны үнээр, тэрбум төгрөгөөр

Он	Нийт үйлдвэрлэл			Нийт борлуулалт		
	Улсын дүн	Үүнээс:		Улсын дүн	Үүнээс:	
		Ундаа үйлдвэрлэл	Нийт үйлдвэрлэлд эзлэх хувь		Ундаа үйлдвэрлэл	Нийт борлуулалтад эзлэх хувь
2008	3,461.3	169.7	4.9	2,877.3	144.4	5.0
2009	3,594.5	163.2	4.5	3,073.5	175.8	5.7
2010	6,481.3	289.3	4.5	4,456.1	275.8	6.2
2011	8,777.3	467.4	5.3	5,596.5	375.5	6.7
2012	9,821.3	553.3	5.6	6,224.1	470.2	7.6
2013	10,443.7	512.8	4.9	6,661.1	445.6	6.7
2014	14,402.9	676.6	4.7	11,108.0	514.1	4.6
2015	14,803.2	642.5	4.3	9,998.1	527.0	5.3
2016	15,663.8	653.8	4.2	11,067.0	605.0	5.5
2017	20,650.4	671.0	3.2	15,160.7	740.9	4.9
2017/2008 %	596.6	395.4	-	526.9	513.1	-

Тайлбар: * - ундаа үйлдвэрлэлд согтууруулах ундаа орсон болно.

Эх үүсвэр: Аж үйлдвэрийн жилийн эцсийн мэдээ, УСХ

Ундаа үйлдвэрлэл 2017 онд аж үйлдвэрийн дэд салбаруудаас үйлдвэрлэлийн хэмжээгээр(мөнгөн дүнгээр илэрхийлсэн) эхний 7-д, борлуулалтаар эхний 6-д оржээ /Хавсралт 1/.

Ундаа үйлдвэрлэл нь аж үйлдвэрийн боловсруулах салбарт хамрагддаг бөгөөд тус салбарт эзлэх үйлдвэрлэлийг авч үзвэл, 2008 онд 15.5 хувийг эзэлж байсан бол 2018 онд 9.3 хувь болж буурчээ.

Ундаа үйлдвэрлэлийн нийт биет хэмжээ 2017 онд 391.8 сая литр болж, 2008 оноос 3 дахин нэмэгдэхэд шар айргийн үйлдвэрлэл 4.1 дахин, цэвэр ус, ундааны төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл 3.2 дахин нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ. Харин архины үйлдвэрлэлийн хэмжээ 1.9 дахин, спирт үйлдвэрлэлийн хэмжээ 1.1 дахин нэмэгдсэн бол дарсны үйлдвэрлэлийн хэмжээ 47.8 хувиар буурсан байна. Ундаа үйлдвэрлэлийн нийт биет хэмжээнд согтууруулах ундааны эзлэх хувь 2000 онд 61.2 байснаа 2008 онд 33.6, 2017 онд 29.4 болж буурсан байна.

Хүснэгт 2. Ундаа үйлдвэрлэлийн биет хэмжээ, бүтээгдэхүүний төрлөөр

Хэмжээ	2008	2017	2017/2008 %
Нийт хэмжээ, мян.л	129,269.9	391,778.3	303.1
Спирт /мян.л/	8,080.9	8,854.5	109.6
Архи /мян.л/	15,297.3	28,802.6	188.3
Дарс /мян.л/	196.6	110.3	56.1
Шар айраг /мян.л/	19,891.0	82,415.2	414.3
Цэвэр ус, амтат ус, ундаа жүүс /мян.л/	85,804.1	275,758.7	321.4

Эх үүсвэр: Аж үйлдвэрийн жилийн эцсийн мэдээ, ҮСХ

Монгол Улсын экспортод гаргасан ус, ундаа архины хэмжээ (мөнгөн дүнгээр) 2018 онд 0.7 мянган ам доллар болж, 2008 оноос 9.3 хувиар, импортоор оруулсан хэмжээ 51.5 мянган ам доллар болж, 2008 оноос 53.8 хувиар нэмэгджээ. Нийт экспорт, импортод ус, ундаа, архины эзлэх хэмжээ маш бага байна /Хавсралт 3/.

Улсын хэмжээнд экспортод гаргасан ус, ундаа, согтууруулах ундааны биет хэмжээ 2018 онд 451.4 мянган литр болж, 2008 оноос 1.9 дахин өсөхөд шар айргийн хэмжээ 36 дахин нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

Хүснэгт 3.1 Экспортод гаргасан ус, ундаа архины төрлийн бүтээгдэхүүний биет хэмжээ

Он	Экспорт					
	Нийт хэмжээ, мян.л	Спирт /мян.л/	Архи /мян.л/	Дарс /мян.л/	Шар айраг /мян.л/	Цэвэр ус, амтат ус, ундаа жүүс /мян.л/
2008	233.9	-	185.7	1.0	10.0	37.1
2009	163.4	-	143.9	0.0	6.1	13.4
2010	269.9	-	237.5	11.1	12.6	8.7
2011	123.7	-	97.0	-	1.8	24.9
2012	90.0	-	32.6	0.4	17.1	39.9
2013	356.2	-	291.9	-	0.1	64.2
2014	143.6	-	106.0	1.1	6.3	30.2
2015	146.4	-	35.8	1.6	75.4	33.6
2016	304.3	-	60.4	1.7	162.4	79.9
2017	437.7	-	28.8	11.4	329.7	67.8
2018	451.4	-	56.8	0.1	360.7	33.8
2018/2008 %	193.0		30.6	14.4	36.0*	90.9

Тайлбар: * - дахин их

Эх үүсвэр: Гадаад худалдааны жилийн эцсийн мэдээ, ҮСХ

Импортоор оруулсан ус, ундаа, согтууруулах ундааны төрлийн бүтээгдэхүүний биет хэмжээ 2018 онд 38.9 сая литр болж 2008 оноос 3.2 хувиар буурчээ. Үүнд шар айргийн хэмжээ 64.1 хувиар буурсан нь голлон нөлөөлсөн байна. Харин архи төрлийн бүтээгдэхүүний хэмжээ 7 дахин, дарсны төрлийн бүтээгдэхүүний хэмжээ 17.8 хувиар, цэвэр ус, ундааны хэмжээ 58.7 хувиар тус тус өссөн байна.


Хүснэгт 3.2 Импорт ороулсан ус, ундаа архины төрлийн бүтээгдэхүүний биет хэмжээ

Он	Импорт					
	Нийт хэмжээ, мян.л	Спирт /мян.л/	Архи /мян.л/	Дарс /мян.л/	Шар айраг /мян.л/	Цэвэр ус, амтат ус, ундаа жүүс /мян.л/
2008	40,246.5	-	242.1	2,677.1	20,469.1	16,858.2
2009	24,673.8	-	161.9	1,340.5	10,629.8	12,541.6
2010	37,283.8	-	208.1	2,347.0	18,847.8	15,880.9
2011	49,383.9	-	598.1	3,430.7	21,943.3	23,411.7
2012	59,738.8	2.0	797.6	3,485.9	28,674.5	26,778.8
2013	65,369.0	0.1	603.7	2,480.3	33,208.0	29,076.9
2014	49,180.3	0.8	718.4	2,594.0	21,676.3	24,190.9
2015	37,365.1	0.5	620.4	2,188.6	15,860.5	18,695.1
2016	42,119.8	0.4	1,044.2	1,981.8	16,684.9	22,408.5
2017	34,750.3	-	1,280.5	2,638.0	6,386.0	24,445.8
2018	38,948.3	0.5	1,687.2	3,153.4	7,355.9	26,751.2
2018/2008 %	96.8	-	696.9	117.8	35.9	158.7

Эх үүсвэр: Гадаад худалдааны жилийн эцсийн мэдээ, ҮСХ

Монгол Улсын хүн амын ихэнх нь Улаанбаатар хотод амьдарч, худалдаа үйлчилгээ төвлөрсөнтэй уялдуулан согтууруулах ундаа борлуулах, үйлчлэх цэгийн тоог авч үзэхэд 2008-2017 онд тасралтгүй өсөж, 2017 онд 4779 болсон нь 2008 оноос 1.4 дахин нэмэгдсэн байна. Согтууруулах ундаа борлуулах, үйлчлэх цэгийг төрлөөр нь авч үзвэл, 2007-2017 оны дунджаар 100 цэг тутмын 56 нь зөвшөөрөлтэй дэлгүүр, 24 нь зоогийн газар болон бар, 9 нь кафе, 7 нь супермаркет, 4 нь хүнсний худалдааны төв болон бөөний худалдааны төвүүд байна /Хавсралт 4/.

Зураг 1. Улаанбаатар хотын согтууруулах ундаа борлуулах, үйлчлэх цэгийн тоо, нэг цэгт ногдох 18, түүнээс дээш насны хүн амын тоо




Эх үүсвэр: Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний цэгийн судалгаа, Нийслэлийн статистикийн газар
Тайлбар: кафе-г согтууруулах ундаа зарах зөвшөөрөлтэй гэж үзээд оруулсан болно.

Улаанбаатар хотын хэмжээнд согтууруулах ундаа борлуулах, үйлчлэх цэгийн тоо өссөнөөр, 1 цэгт ногдох 18, түүнээс дээш насны хүн амын тоо 2008 онд 215 байснаа 2017 онд 195 болж буурчээ.

Согтууруулах ундаа борлуулах, үйлчлэх цэгийг дүүргээр авч үзвэл, 2017 онд нийт цэгийн 20.8 хувь нь Сонгинохайрхан дүүрэгт, 20.7 хувь нь Баянзүрх дүүрэгт, 18.2 хувь нь Баянгол дүүрэгт, 13.7 хувь нь Сүхбаатар дүүрэгт, 12.1 хувь нь Чингэлтэй дүүрэгт, 9.4 хувь нь Хан-Уул дүүрэгт, үлдсэн 5.0 хувь нь Налайх, Багануур, Багахангай дүүрэгт байршиж байна.

Үүнийг төрлөөр нь харвал, Сонгинохайрхан, Баянзүрх дүүрэгт худалдааны цэг болох зөвшөөрөлтэй дэлгүүрүүд, харин Баянгол, Сүхбаатар дүүрэгт үйлчилгээний цэгүүд болох зоогийн газар, бар, кафе төвлөрсөн байна.

УЛААНБААТАР ХОТЫН СОГТУУРУУЛАХ УНДАА БОРЛУУЛАХ, ҮЙЛЧЛЭХ ЦЭГҮҮД, 2010, 2017 он



Тайлбар: бусад гэдэгт хүнсний худалдааны төв, бөөний төв болон супермаркетинг хамруулав.

Үндэсний статистикийн хорооноос 2013 онд явуулсан Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгааны дүнгээр улсын хэмжээнд сүүлийн 1 сарын хугацаанд 15-54 насны эрэгтэйчүүдийн 2 эрэгтэй тутмын 1 (52.4 хувь), 15-49 насны эмэгтэйчүүдийн 3 эмэгтэй тутмын 1 (29.5 хувь) согтууруулах ундаа хэрэглэсэн байна. Энэ судалгаа нь согтууруулах ундааны хэрэглээний ерөнхий дүр зургийг харуулснаас хэрэглэсэн хэмжээг харуулаагүй болно. Тиймээс насанд хүрсэн 1 хүний жилд хэрэглэсэн согтууруулах ундааны хэмжээг үйлдвэрлэл болон Нөөц ашиглалтын хүснэгтийн ашиглалт/зарцуулалтын хэмжээтэй харьцуулж дараах байдлаар тооцоо хийлээ.

Хүснэгт 4. Дотоодын зах зээл дэх согтууруулах ундааны нийлүүлэлт, хэрэглээ, насанд хүрсэн 1 хүнд ногдох жилийн дундаж хэмжээ

Үзүүлэлт	2008	2010	2012	2014	2016	2017	2018
I. 18, түүнээс дээш насны жилийн дундаж хүн ам, мянгаар	1,669.1	1,762.1	1,833.8	1,968.9	1,979.2	1,990.9	2,016.3
II.1 Дотоодын зах зээл дэх согтууруулах ундааны нийлүүлэлтийн хэмжээ (дотоодын нийт үйлдвэрлэл+импорт-экспорт)							
Нийт хэмжээ, мян.л	58,576.4	86,411.9	124,914.3	116,874.1	119,106.3	117,099.7	131,937.8
Архи	15,353.6	20,215.4	27,566.8	24,793.8	24,791.9	25,899.0	30,433.0
Дарс	2,872.7	2,482.8	3,565.5	2,669.6	2,059.6	2,729.2	3,263.6
Шар айраг	40,350.1	63,713.7	93,782.1	89,410.8	92,254.8	88,471.5	98,241.2
<i>Дотоодын зах зээлд дотоодын үйлдвэрлэлээс оруулсан хэмжээ, хувиар</i>							
Дүнд эзлэх хувь	60.1	75.2	73.6	78.6	83.5	91.2	90.8
Архи	98.4	99.0	97.1	97.1	95.8	95.1	94.5
Дарс	6.8	5.5	2.2	2.8	3.8	3.3	3.4
Шар айраг	49.3	70.4	69.4	75.8	81.9	92.8	92.5
<i>Дотоодын зах зээлд импортоор оруулсан хэмжээ, хувиар</i>							
Дүнд эзлэх хувь	39.9	24.8	26.4	21.4	16.5	8.8	9.2
Архи	1.6	1.0	2.9	2.9	4.2	4.9	5.5
Дарс	93.2	94.5	97.8	97.2	96.2	96.7	96.6
Шар айраг	50.7	29.6	30.6	24.2	18.1	7.2	7.5
II.2 Дотоодын зах зээл дэх согтууруулах ундааны нийлүүлэлтээс өрх, хүн амын хэрэглэсэн хэмжээ*							
Нийт хэмжээ, мян.л	47,036.9	69,388.7	100,306.2	93,849.9	95,642.4	94,031.1	105,946.0
Архи	12,329.0	16,232.9	22,136.1	19,909.4	19,907.9	20,796.9	24,437.7
Дарс	2,306.8	1,993.7	2,863.1	2,143.7	1,653.9	2,191.6	2,620.7
Шар айраг	32,401.1	51,162.1	75,307.0	71,796.8	74,080.6	71,042.6	78,887.7
III. 18, түүнээс дээш насны 1 хүнд ногдох:							
<i>- дотоодын зах зээл дэх согтууруулах ундааны нийлүүлэлтийн жилийн дундаж хэмжээ, литрээр</i>							
Нийт	35.1	49.0	68.1	59.4	60.2	58.8	65.4
Архи	9.2	11.5	15.0	12.6	12.5	13.0	15.1
Дарс	1.7	1.4	1.9	1.4	1.0	1.4	1.6
Шар айраг	24.2	36.2	51.1	45.4	46.6	44.4	48.7
<i>- Өрх, хүн амын хэрэглэсэн жилийн дундаж хэмжээ, литрээр</i>							
Нийт	28.2	39.4	54.7	47.7	48.3	47.2	52.5
Архи	7.4	9.2	12.1	10.1	10.1	10.4	12.1
Дарс	1.4	1.1	1.6	1.1	0.8	1.1	1.3
Шар айраг	19.4	29.0	41.1	36.5	37.4	35.7	39.1


Тайлбар: * - Зах зээл дэх согтууруулах ундааны нийлүүлэлтийн 80.3% нь өрх, хүн амын хэрэглээнд зарцуулагдсанаар тооцов.

Үүнд: Нөөц ашиглалтын хүснэгт³ (мөнгөн дүнгээрх)-ээс харахад зах зээл дэх согтууруулах ундааны нийлүүлэлтийн(дотоодын үйлдвэрлэл, импортын нийлбэрээс экспортыг хассан)зарцуулалтыг 2010-2016 оны дунджаар авч үзвэл, 13.4 хувийг завсрын хэрэглээнд, 80.3 хувийг өрх, хүн амын хэрэглээнд зарцуулсан бол 6.2 хувь нь нөөцөд үлдэж, 0.1 хувийг экспортолсон байна. Энэ бүтцийг согтууруулах ундааны биет хэмжээг ашиглан согтууруулах ундааны (спиртийг оруулаагүй) насанд хүрсэн 1 хүний хэрэглэсэн жилийн дундаж хэмжээг тооцоход 2018 онд 52.5 литр болж, 2008 оноос 1.9 дахин өссөнөөс шар айргийн хэрэглээний хэмжээ 2 дахин, архины хэрэглээний хэмжээ 1.6 дахин нэмэгдсэн байна.

Насанд хүрсэн нэг хүний жилийн дундаж хэрэглээг сараар, нийтлэг савлагааны хэмжээгээр тооцвол, 2018 онд насанд хүрсэн 1 хүн сард дунджаар архи 2 шил (0.5л-тэй), шар айраг 6 лааз (0.5л-тэй), харин 100 мл дарс хэрэглэсэн байна. Энэ нь 2008 оноос 1 шил архи, 3 лааз шар айргаар нэмэгджээ.

Согтууруулах ундааны төрлөөр авч үзвэл, сүүлийн 11 жилийн хугацаанд насанд хүрсэн нэг хүний жилийн дундаж шар айргийн хэрэглээ 2 дахин, архины хэрэглээ 1.6 дахин өссөн бол дарсны хэрэглээ 6 хувиар буурчээ.


Зураг 1.1 Насанд хүрсэн нэг хүний жилийн дундаж согтууруулах ундааны хэрэглээ, төрлөөр



Насанд хүрсэн нэг хүний жилийн дундаж хэрэглээ болон хэрэглээний бараа, үйлчилгээний сагсанд сонгогдсон нэр төрлийн бүтээгдэхүүний жилийн дундаж үнийг зэрэгцүүлэхэд үнэ тогтмол өссөн, хэрэглээ нь нэмэгдсэн байна. Эндээс үнэ өссөн хэдий ч хэрэглээ буурахгүй зүй тогтол байгаа нь үйлдвэрлэл, нийлүүлэлтээс шалтгаалахгүй хүмүүсийн хэрэглээ нэмэгдэж байгаа харууллаа.

³Нөөц ашиглалтын хүснэгт нь салбаруудын бараа, үйлчилгээний хэрэглээ буюу завсрын хэрэглээ болон эцсийн ашиглалтын бүрэлдэхүүнийг бүтээгдэхүүнээр харуулдаг.

Зураг 1.2 Согтууруулах ундааны жилийн дундаж үнэ, төгрөгөөр, насанд хүрсэн 1 хүний жилийн дундаж хэмжээ



Тайлбар: Эдгээр нь үнийн мэдээнд ашигладаг өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний жагсаалтад орсон бүтээгдэхүүн болно.

Архинаас үүдэн хүн амд гарч байгаа зарим хор уршгийн талаар

Гэр бүлийн хүчирхийлэл: Согтууруулах ундааг хэтрүүлэн хэрэглэснээр гэр бүлийн хүчирхийлэл гарахад нөлөө үзүүлж байна. Тухайлбал, ҮСХ-ноос 2017 онд улсын хэмжээнд зохион байгуулсан жендэрт суурилсан хүчирхийллийн судалгааны дүнгээр бие махбодын хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдээс (судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн 29.7 хувь) хүчирхийллийн шалтгааныг асуухад 62.2 хувь нь нөхөр/хамтрагч нь архи ууж согтуу байсан нь хүчирхийлэл үйлдэхэд нөлөөлсөн гэж хариулжээ⁴.

Гэмт хэрэг: Дотоодын зах зээл дэх согтууруулах ундааны нийлүүлэлтийн хэмжээ 2013 онд хамгийн өндөр байх үед согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн тоо мөн өндөр, бүртгэгдсэн гэмт хэргийн 12.4 (4012) хувийг эзэлж байжээ⁵.

Зураг 2. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, гэмт хэргийн байдлаар, 2007-2017 он



⁴ http://web.nso.mn/nadamn/index.php/catalog/246/related_materials


⁵ http://1212.mn/BookLibraryDownload.aspx?url=crime_2017.pdf&ln=Mn

Зам тээврийн осол: Улсын хэмжээнд 2017 онд жолооч архи, согтууруулах ундааны зүйл хэрэглэснээс үүдэн 793 зам тээврийн осол гарсны 41.0 хувь нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн байна. Жолоочийн буруугаас шалтгаалсан ослын 2.2 хувь нь согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон бол явган зорчигчийн буруутай үйлдлээс бүртгэгдсэн ослын 32.9 хувийг явган зорчигч согтуугаар замын хөдөлгөөнд оролцсоноос осол гарсан байна⁶.

Албадан эрүүлжүүлэгдсэн хүмүүс: Монгол Улсын Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг эрүүлжүүлэх байранд “Өөрийн үйлдлийг удирдан хянах чадваргүй болтлоо согтсоны улмаас хаана байгаага болон очих газраа мэдэхгүй болсон, гудамж талбай, олон нийтийн газар ухаангүй унасан, энэ байдлаас болж өөрөө осол гэмтэл, гэмт хэрэг, зөрчилд өртөж болзошгүй болсныг үндэслэл болгон цагдаагийн алба хаагч тухайн этгээдийг хамгаалах, тусламж үзүүлэх зорилгоор эрүүлжүүлэх байранд хүлээлгэн өгнө” гэж заасан байдаг.

Цагдаагийн ерөнхий газрын мэдээллийн санд бүртгэгдсэнээр албадан эрүүлжүүлсэн хүмүүс (давхардсан тоогоор) 2010 онд 109.8 мянга, 2013 онд 123.5 мянга (энэ үед дотоодын зах зээл дэх нийлүүлэлт өндөр байсан) 2018 онд 85.8 мянга байна. Насанд хүрсэн (18, түүнээс дээш) 1000 хүн тутамд ногдох эрүүлжүүлсэн хүний (давхардсан) тоо 2010 онд 59, 2013 онд 62, 2018 онд 41 болжээ.

Зураг 3. Эрүүлжүүлэгдсэн хүний тоо, 1000 хүнд ногдохоор, 2010-2018 он



Эндээс нэг хоногт эрүүлжүүлсэн тохиолдлыг тооцвол, 2013 онд 338 байсан бол 2018 онд 235 болон буурчээ.

Нийслэл хотод 2013 онд 67.7 мянган эрүүлжүүлсэн тохиолдол бүртгэгдэж байсан бол 2018 онд 56.1 мянга болжээ. Нийслэлийг оруулахгүйгээр бусад аймгийг зэрэгцүүлэхэд 2018 онд хамгийн бага нь Говь-Алтай (332), хамгийн их нь Дархан-Уул (4.5 мянга) аймаг байна. Харин 2013 оны дүнгээр Дорнод (7.2 мянга) аймаг хамгийн олон, Булган (769) хамгийн бага эрүүлжүүлсэн тохиолдолтой байжээ. 2018 оны албадан эрүүлжүүлсэн тохиолдлын тоог 2013 онтой харьцуулахад Өмнөговь, Сүхбаатар аймагт 5 дахин, Говь-Алтай, Өвөрхангай аймагт 3 дахин буурсан байна.

2018 оны байдлаар албадан эрүүлжүүлэгдсэн (давхардсан тоогоор) хүний тоо 85.8 мянга байгаас 4.6 мянга нь давтан эрүүлжүүлэгджээ.

⁶http://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=Road_traffic_accidents_2017.pdf&In=Mn

2018 онд эрүүлжүүлэгдсэн 81.2 мянган хүний мэдээллээс /дэлгэрэнгүйг хавсралт 6-9-д тусгав/:


- Эрүүлжүүлэгдсэн хүмүүс 15, түүнээс дээш насны хүн амын 3.7 хувийг эзэлж байна.
- 92.5 хувь (75.1 мянга) нь эрэгтэй, 7.5 хувь (6.1 мянга) нь эмэгтэй, насны бүлгээр авч үзвэл, 25-39 насныхан хамгийн их буюу 52.9 хувийг эзэлж байна. Мөн 15 хүртэлх насны 5 хүүхэд эрүүлжүүлэгджээ.

Зураг 4. Албадан эрүүлжүүлэгдсэн хүний тоо, насны бүлгээр, 2018 он




- Эрүүлжүүлэгдсэн 10 хүн тутмын 9 нь дунд зэргийн согтолттой байна.
- Эрүүлжүүлэгдсэн нийт хүний 55.0 хувь нь гэр, орон сууцнаас, 33.5 хувь нь гудамж, талбайгаас хүргэгдэж ирдэг бол 4.2 хувь нь бар, цэнгээний газраас хүргэгдсэн байна.
- Албадан эрүүлжүүлэгдэхээр ирж байгаа 10 хүн тутмын 8 нь бусдын амгалан тайван байдлыг алдагдуулсан, 1 нь согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ гэмт хэрэг, зөрчилд холбогдсон.
- Эрүүлжүүлэгдсэн хүмүүсийн 5.8 хувь нь согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодож байжээ.
- Албадан эрүүлжүүлэгдсэн хүмүүсийн 76.1 хувь нь бүрэн дунд, 12.9 хувь нь бүрэн бус дунд, 4.5 хувь нь дээд, 2.1 хувь нь бага боловсролтой, 1 хувь нь боловсролгүй байна
- Ажил эрхлэлт, нийгмийн байдлыг авч үзэхэд 80.8 хувь нь тодорхой эрхэлсэн ажилгүй, 6.3 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 1.4 хувь нь төрийн албан хаагчид байна.


- Долоо хоногийн гарагийн хувьд Мягмар (12028 хүн) болон Бямбад (11859 хүн) хамгийн их хүн эрүүлжүүлэгдсэн байна.




- 10 дугаар сард 7715 хүн эрүүлжүүлэгдсэн нь хамгийн их, 8 дугаар сард 5909, 9 дүгээр сард 5913 байгаа нь хамгийн бага байна.



- Нийслэлийг оруулахгүйгээр бусад аймгийг зэрэгцүүлэхэд хамгийн бага нь Говь-Алтай (306 хүн), хамгийн их нь Дархан-Уул (4.2 мянга) аймаг байна.



- Нийслэлд эрүүлжүүлэгдсэн хүмүүс ихэнх нь буюу 78.4 % нь гэр хороололд амьдардаг байна.



ДҮГНЭЛТ

Дотоодын зах зээл дэх согтууруулах ундааны хэмжээ (спиртийг оруулаагүй) 2008 онд 58.6 сая литр байснаа 2018 оны 131.9 сая литр болж 2.2 дахин нэмэгджээ. Зах зээл дэх бүтцийн хувьд дотоодын үйлдвэрлэлийн хэмжээ нэмэгдэж, харин импортын хэмжээ буурсан байна.

Насанд хүрсэн нэг хүний жилийн дундаж согтууруулах ундааны хэрэглээ сүүлийн 11 жилийн хугацаанд 28.2 литрээс 52.5 литр болж 1.9 дахин өссөн байгаагаас үзвэл хүн амын архи, согтууруулах ундааны хэрэглээ үйлдвэрлэл, нийлүүлэлтийн хэмжээнээс шалтгаалахгүй өсөж байна.

Жендэрт суурилсан хүчирхийллийн судалгааны дүн болон Цагдаагийн байгууллагын мэдээллийн санд бүртгэгдсэн 2018 оны мэдээгээр нийт албадан эрүүлжүүлэгдсэн хүний 55 хувь нь гэр, орон сууцнаас ирснээс үзэхэд архи согтууруулах ундааны зохисгүй хэрэглээ гэмт хэрэг, зөрчил түүний дотор гэр бүлийн хүчирхийллийн хэрэг, зөрчил үйлдэгдэх нэг суурь шалтгаан, хүчин зүйл болж байгааг харуулж байна

Согтууруулах ундааны нийлүүлэлт, хэрэглээ, үнийн өсөлтийг үндэслэн дүгнэхэд архины хэрэглээнээс үүдэн хүний эрүүл мэнд, аюулгүй байдал, нийгэм-эдийн засагт гарах сөрөг нөлөөг багасгахад үр дүнтэй, уялдаа холбоотой, олон талын оролцоог хангах, урт хугацааны тогтвортой бодлого, хөтөлбөр хэрэгжүүлэх шаардлагатай байна. Тухайлбал,

Үнэ болон эдийн засгийн зохицуулалт, хязгаарлалт:

- 1990-ээд оноос өмнө архины үнэ дунджаар литр нь 74 төгрөг (1987 он) байгаа нь өргөн хэрэглээний бараа болох талхны үнээс даруй 43 дахин өндөр, өөрөөр хэлбэл, үнийг өндөр тогтоож, хэрэглээнд нөлөөлдөг байсан байна. Тиймээс дотоодын зах зээлд борлуулах үнийг татвар нэмэгдүүлэх замаар өсгөх арга хэмжээг урт хугацаанд тогтвортой хэрэгжүүлэх

Хэрэглээнд нөлөөлөх хязгаарлалт:

- Согтууруулах ундаа борлуулах, үйлчлэх зөвшөөрөлтэй цэгүүдийг нэгдсэн стандарттай, цэгцтэй болгох.
- Согтууруулах ундаа худалдах, үйлчлэх үйлчилгээний цагийн хязгаарлалтыг нэмэх, хяналтыг сайжруулах.
- Албадан эрүүлжүүлэхийн хоногийн төлбөрийг үнийн өсөлттэй уялдуулан тогтоодог байх (2007онд эрүүлжүүлэх байрны хоногийн төлбөр 4150 гэж тогтоогдсон өнөөг хүртэл хэвээр байна).

Согтууруулах ундааг хэтрүүлэн хэрэглэснээр гарах эрүүл мэнд, нийгэмд гарах сөрөг нөлөөний талаар олон нийтэд таниулах:

- Эрүүл мэндийн нэгдсэн мэдээллийн санг сайжруулах, албадан эрүүлжүүлэгдэж байгаа хүмүүсийг эрүүл мэндийн сургалтад хамруулах, нийгмийн тустай хөдөлмөр эрхлүүлэх ажлыг хэвшил болгон сайжруулах.
- Хүн амын насны онцлогтой уялдуулсан архи хэтрүүлэн хэрэглэснээс гарах эрүүл мэндийн сөрөг нөлөөний талаар болон архины хэрэглээг зохистой байлгах талаар мэдлэг, мэдээлэл олгоход боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний бүх үе шатуудад нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэх.